

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР

Санамж: 1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэг хариултыг сонгоорой

1. Хүмүүс хоорондоо харилцахдаа мэдээлэл болон утгыг нүүрний хувирал, дууны өнгө, дохио зангаа, биеийн үйл хөдлөлөөр илэрхийлж ойлголцдог. Энэ нь нийгмийн ямар ойлголтын жишээ вэ? **/1 оноо/**

- A. Нийгмийн харилцан үйлдэл
B. Нийгмийн үүрэг
C. Иргэний үүрэг
D. Нийгмийн байр суурь
E. Нийгмийн шинж

2. Цэгийн оронд тохирох хариултыг олно уу?нь тийм, үгүй эсвэл сайн, дунд, муу гэх мэт зөвхөн тодорхой тогтсон хариултаас сонгохыг оролцогчоос хүсдэг. Энэ нь: **/1 оноо/**

- A. Ганцаарчилсан асуулт
B. Нээлттэй асуулт
C. Хагас нээлттэй асуулт
D. Хаалттай асуулт
E. Чөлөөт асуулт

3. Нийгэмшилт нь хүний насан туршид явагддаг хэмээх санааг анх удаа судлаач Орвиль Г.Брим дэвшүүлсэн байдаг. Тэгвэл түүний үзэж буйгаар насанд хүрэгчдийн нийгэмшилтийн шинж аль нь вэ? **/1 оноо/**

- A. Зан төлвийн сэдлийг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.
B. Суурь үнэлэмж баримжаалалд нөлөөлдөг.
C. Хэм хэмжээг эзэмшиж чаддаг.
D. Туршлага, арга барил эзэмшихэд чиглэгдэнэ.
E. Дүрэм биелүүлэх, анхааралтай дуулгавартай байхад сургадаг.

4. Нийгмийн хэм хэмжээнээс хазайсан үйлдлийг нийгмийн гажуудал гэж нэрлэдэг. Тэгвэл гажуудлын шалтгааныг тайлбарласан эрдэмтнийг нэрлэнэ үү? **/1 оноо/**

- A. Т.Парсонс
B. К.Маркс
C. Р.Мертон
D. М.Вебер
E. Э.Дюркгейм

5. Т.Парсонс нийгмийн хяналтын гурван аргыг нарийвчлан судалсан байдаг. Эдгээр аргуудыг тайлбартай нь хамт зөв харгалзуулна уу? **/2 оноо/**

1. Тусгаарлах	A. Гажуудагчийг нийгмийн хэм хэмжээг биелүүлэхэд бэлэн болсон үед нийгмийн дотор буцаж орохыг зөвшөөрдөг.
2. Онцгойруулах	B. Энгийн амьдралд буцаж орох нийгмийн дотор үүргээ биелүүлэхэд бэлтгэдэг.
3. Цагаатгах	C. Гажуудагчийг бусад хүмүүсээс салгах зорилготой бөгөөд засан хүмүүжүүлэх оролдлогогүй.

- A. 1b 2a 3c
B. 1a 2b 3c
C. 1c 2a 3b
D. 1a 2c 3b
E. 1c 2b 3a

6. Нэгдмэл нутаг дэвсгэр, эдийн засаг, соёл, хэл, өөрийн ухамсраар нэгдэн төр улс болж зохион байгуулагдсан хүмүүсийн хамтын нийгэмлэг нь нийгмийн нийтлэгийн аль хэлбэрийг илэрхийлсэн ойлголт вэ? **/1 оноо/**

- A. Үндэстэн
B. Аймаг
C. Овог
D. Ястан
E. Угсаатан

7. Уулархаг, хуурай уур амьсгалтай газрын хүмүүс зэрлэг амьтныг идээшлүүлж мал маллан амьдрах болж, чийглэг бороо хур ихтэй газрынхан гар багаж зэвсэг ашиглан, газар тариалан эрхлэж, илүүдэл бүтээгдэхүүн үйлдвэрлэн хагас нүүдэллэн амьдардаг. Энэ нь нийгмийн ямар хэв маяг вэ? **/2 оноо/**

- A. Ан агнуур, түүврийн нийгэм
B. Тариалан, мал аж ахуйн нийгэм
C. Хөдөө аж ахуйн нийгэм
D. Аж үйлдвэржсэн нийгэм
E. Аж үйлдвэржсэний дараах нийгэм

8. Найз нөхөд, танилуудтайгаа харилцаж, соёл урлаг, спортын үйл ажиллагаанд оролцох нь нийгмийн оролцооны ямар ангиллын жишээ вэ? **/1 оноо/**

- A. Олон нийтийн оролцоо
B. Албан ёсны оролцоо
C. Идэвхтэй оролцоо
D. Нийгмийн оролцоо
E. Албан бус оролцоо



9. Нийгэмд давхраажилт бүрэлдэх нөхцөлүүдийг зөв харгалзуулна уу? **/2 оноо/**

1	Нийгмийн тэгш бус байдал	a	Адил бус боломж бүхий байдал
2	Нийгмийн ялгарал	b	Тодорхой хэв шинжит харилцаа бүхий тэгш бус байдлын тогтолцоо
3	Нийгмийн давхраажилт	c	Нийгмийн гишүүд хувийн болон нийгмийн шинжээрээ зааглагдан хуваагдах байдал

A. 1b 2a 3c B. 1a 2c 3b C. 1a 2b 3c D. 1c 2b 3a E. 1b 2c 3a

10. Үндэсний статистикийн хорооны “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-гаар /2012 он/ нийт өрхийн 27,8% нь ядуурлын шугамаас доогуур түвшинд буюу ядууралд өртсөн гэж үзжээ. Тэрхүү судалгаанд дурьдагдсан ядууралд илүү өртөх эрсдэлтэй бүлгийг тоочихдоо илүүц зүйл дурьдсан бол аль нь вэ? **/2 оноо/**

A. Боловсролгүй эсвэл бага боловсролтой тэргүүнтэй өрх
B. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд C. Олон хүүхэдтэй өрх D. Ахмад настан
E. Гурав буюу түүнээс дээш ихэр хүүхэдтэй өрх

11. “Соёл нь хүн нийгмийн гишүүн болохынхоо хувьд эзэмшдэг мэдлэг, итгэл үнэмшил, урлаг, ёс суртахуун, хууль, зан заншил болон бусад чадвар, дадлуудыг багтаасан цогц бүхэл юм” гэж дараах эрдэмтдээс хэн нь үзсэн бэ? **/1 оноо/**

A. Э. Кассирер B. Э.Дюркгейм C. Ж. Мёрдок
D. Э. Тайлор E. К.Ясперс

12. Цэгийн оронд тохирох хариултыг олно уу?нь нийгэмд хэм хэмжээний шинжтэй болж тогтож хэвшсэн нийтлэг ёс журмыг хэлнэ. Энэ нь: **/1 оноо/**

A. Ёс суртахууны хэм хэмжээ B. Ёс суртахуун
C. Ёс суртахууны ухамсар D. Ёс суртахууны харилцаа
E. Ёс суртахууны үйлдэл

13. Соёлын зүйл нэг бүлгээс нөгөөд, нэг нийгмээс нөгөөд дэлгэрэх үйл явцыг юу гэдэг вэ? **/1 оноо/**

A. Соёлын нэвчилт B. Соёлын цочрол C. Соёлын хямрал
D. Соёлын нэгдэл E. Соёлын хуримтлал

14. Юуг зөв гэж хүлээн зөвшөөрөх, юуг буруу зохисгүй гэж үзэх талаар нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эрхэм чанаруудыг юу гэх вэ? **/2 оноо/**

A. Үнэт зүйл B. Үнэлгээ C. Үнэлэмж D. Ёс суртахуун E. Соёл

15. Урлагийн бүтээлийг зориулалт, өнгө аяс, уран сайхны шинжээр нь ангилахдаа хамааралгүй зүйл дурьдсан бол аль нь вэ? **/1 оноо/**

A. Ардын урлаг B. Хээнцэр урлаг
C. Олон нийтэд зориулсан урлаг D. Сонгодог урлаг E. Элит урлаг

16. Бусдын эрхийг хүндэтгэх, хуулийн өмнө тэгш эрхтэй байх зэрэг нь соёлын ямар хэлбэрээр илрэн гарч байна вэ? **/2 оноо/**

A. Ахуйн соёл B. Эдийн засгийн соёл C. Эрх зүйн соёл
D. Экологийн соёл E. Сэтгэлгээний соёл

17. Тухайн улс орон дахь хүмүүсийн нийтлэг итгэл үнэмшил, бэлгэдэл, зан үйлийн хэв загвар, үнэт зүйлс, хэм хэмжээг тодорхойлж байдаг соёлыг юу гэж нэрлэх вэ? **/2 оноо/**

A. Зонхилогч соёл B. Үндэсний соёл C. Нийтийн соёл
D. Шашны соёл E. Мэргэжлийн соёл



18. Бусад үндэстнийг дорд үзэх, хүүхэд хөгшидтэй харгис хэрцгий хандах, хүрээлэн буй орчиндоо хор хөнөөл учруулах зэргийг ямар соёл гэх вэ? **/1 оноо/**

- A. Соёлын цочирдол
D. Сөрөг соёл
- B. Соёлын орон зай
E. Соёлын гажилт
- C. Соёлын эрх чөлөө

19. Дараах бодомжуудын аль нь буруу томъёологдсон байна вэ? **/1 оноо/**

- A. Соёлын үнэлэмж ба хэм хэмжээнүүд заримдаа өөр хоорондоо зөрчилдөх үед соёлын зөрөлдөөн гарч болно.
- B. Хэм хэмжээ үнэлэмж, ёс заншлууд бие биеэ дэмждэг нь соёл нэгдэлтэй байгаагийн шинж юм
- C. Соёлын нийтлэг талууд нь хүн төрөлхтний соёл нэгдэлтэй болохыг илэрхийлдэг
- D. Өөр өөр нийгэм, үндэстэн, угсаатны соёл бүр өөрийн онцлогтойн зэрэгцээ нийтлэг талуудтай байдаг
- E. Орчин үеийн үйлдвэрлэл болон мэдээлэл технологийн хөгжлийн ачаар дэлхийн хүн амын хэрэглээ, харилцаа холбоо улам өөр болсоор байна.

20. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу? **/1 оноо/**

1	Материаллаг хэрэгцээ	A	Судалгааны ажил хийх, ном бүтээл туурвих
2	Бүтээн туурвих хэрэгцээ	B	Амьдралын нөхцлөө сайжруулах, орон байртай болоход анхаарах
3	Өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээ	C	Боловсролын зэргээ ахиулах, мэргэжилтэй болох

- A. 1a 2b 3c B. 1b 2a 3c C. 1c 2a 3b D. 1a 2c 3b E. 1c 2b 3a

21. НЭ>НН үед макро эдийн засагт ямар үзэгдэл бий болох вэ? **/1 оноо/**

- A. Макро эдийн засагт тэнцвэр бий болно.
- B. Үйлдвэрлэсэн баялгийн борлуулалт буурснаар эдийн засаг уналтад орж, ажилгүйдэл үүснэ.
- C. Бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ өсч инфляци бий болно.
- D. Бүтээгдэхүүн үйлчилгээний үнэд өөрчлөлт орохгүй.
- E. Макро эдийн засагт ямар нэг сөрөг үзэгдэл бий болохгүй.

22. ДНБ /дотоодын нийт бүтээгдэхүүн/ –ийг зардлаар нь тооцох аргыг нэрлэхдээ илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? **/1 оноо/**

- A. ААН-ийн хөрөнгө оруулалтын зардал
C. Түрээсийн төлбөр
- B. Өрх гэрийн хэрэглээний зардал
D. Төрийн зардал
- E. Гадаадын хэрэглэгчийн зардал

23. Депозит мөнгө гэж юуг нэрлэдэг вэ? **/1 оноо/**

- A. Банкны хадгаламжид үндэслэн нэг тооцооны данснаас нөгөөд мөнгө шилжүүлэх банк хоорондын тооцооны тогтолцоо
- B. Тодорхой хугацаанд өрөө төлөх тухай зээлдэгчийн хүлээсэн үүргийг гэрчилсэн өр төлөх баталгаа
- C. Төв банкнаас гаргадаг мөнгөн тэмдэгт, банкны тасалбар
- D. Данснаас тодорхой хэмжээний мөнгө авах тухай өмчлөгчийн зөвшөөрөл
- E. Компьютерийн тусламжтайгаар хийгддэг банкны тооцооны тогтолцоо

24. Төв банкны үүрэгт хамааралгүй өгөгдлийг олно уу? **/2 оноо/**

- A. Гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж зохицуулах
- B. Эдийн засаг дахь мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх
- C. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах
- D. Арилжааны банкны үйл ажиллагаанд хяналт тавих
- E. Иргэдийн мөнгөн хөрөнгийг хадгалж банк хооронд гүйлгээ хийх



25. Дараах бодомжуудын аль нь ажилгүйдлийн түвшинг зөв тодорхойлсон байна вэ? /1 оноо/

- A. Хөдөлмөрийн чадвартай ажилгүй хүн амын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулах
- B. Нийт ажиллагсадын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулах
- C. Хөдөлмөрийн чадваргүй хүн амын тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулах
- D. Тохирох хариулт алга
- E. Хөдөлмөрийн чадвартай ажилгүй хүн амын тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулах

26. Мөнгө өөрийн үүргүүдээ бүх талаар алдаж үнэт талон, купон, бараа зэрэгт байр сууриа тавьж өгөхөд хүрдэг инфляцийг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/

- A. Зохисгүй инфляци
- B. Мөлхөө инфляци
- C. Цогио инфляци
- D. Хэвийн инфляци
- E. Хэтрүү /гипер/ инфляци

27. Английн эрдэмтэн М.Кейнс эдийн засгийн уналт болон ажилгүйдлийн шалтгааныг эдийн засгийн ямар ойлголттой холбон тайлбарласан байдаг вэ? /1 оноо/

- A. Нийт нийлүүлэлт
- B. Нийт эрэлт
- C. Мөнгөний бодлого
- D. Эдийн засгийн үр өгөөж
- E. Эдийн засгийн ашиг

28. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу? /2 оноо/

1	Шууд хөрөнгө оруулалт	a	Гадаад орнуудад хоёр болон түүнээс олон үйлдвэрлэл үйлчилгээний салбартай байх
2	Портфелийн хөрөнгө оруулалт	b	Компани бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэр байгуулах эсвэл худалдаж авах
3	Үндэстэн дамнасан корпораци	c	Тухайн орны үнэт цаасыг гадаадын худалдан авагчдад худалдах

- 1a 2b 3c
- B. 1b 2c 3a
- C. 1c 2a 3b
- D. 1b 2a 3c
- E. 1c 2b 3a

29. Нөхөж бичнэ үү? Олон улсын худалдаа гэдэг нь.....хэлнэ. /2 оноо/

- A. Бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад орнуудад борлуулахыг хэлнэ.
- B. Экспорт, импортын зөрүүг хэлнэ.
- C. Экспорт, импортын нийлбэрийг хэлнэ.
- D. Улс орон хоорондын бараа, үйлчилгээний шилжих хөдөлгөөнийг хэлнэ.
- E. Бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад орнуудаас худалдаж авахыг хэлнэ.

30. Олон улсын эдийн засагт улс орнуудын эзлэх байр суурийг тодорхойлдог шалгууруудыг тоочихдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? /2 оноо/

- A. Эдийн засгийн бодлого
- B. Эдийн засгийн хөгжлийн түвшин
- C. Эдийн засгийн бүтэц
- D. Эдийн засгийн өсөлтийн төрөл
- E. Гадаад эдийн засгийн хэлбэр

31. Улс төрийн засаглалын субъектэд аль нь үл хамаарах вэ? /1 оноо/

- A. Хүмүүсийн нийтлэг
- B. Хувь хүн
- C. Байгууллага
- D. Эрх мэдэл
- E. Ард түмэн

32. Эрх мэдлийг телеологийн хандлагаар нь хэрхэн тодорхойлдог вэ? /1 оноо/

- A. Эрх мэдэл гэдэг нь нийгмийн бүлгийн өөрсдийгөө зохион байгуулах арга хэрэгсэл юм.
- B. Эрх мэдэл нь улс төрийн зан үйлийн өвөрмөц хэв маяг юм.
- C. Эрх мэдэл нь тавьсан зорилгоо хэрэгжүүлэх чадвар, үйл ажиллагаа юм.
- D. Эрх мэдэл нь улс төрийг хэрэгжүүлэх хэрэгсэл юм.
- E. Эрх мэдэл нь захирагч, захирагдагч хоёрын харилцааны нэг өвөрмөц шинж юм.



33. Улс төрийн тогтолцооны оролт, гаралт нь юуны тусламжтайгаар өөр хоорондоо харилцан шүтэлцэж байдаг вэ? **/1 оноо/**

- A. Дэмжлэг B. Эргэх холбоо C. Шаардлага D. Шийдвэр E. Үйлдэл

34. Нийгэм дэх олон бүлгийн сонирхлыг илрүүлэн гаргах чиг үүргийг юу гэж нэрлэх вэ?

/1 оноо/

- A. Страфикаци B. Агрегаци C. Интеграци
D. Даяарчлал E. Артикуляци

35. Ямар шалгуурыг үндэслэн улс төрийн намуудыг нэг намын, хоёр намын, олон намын тогтолцоотой гэж ангилдаг вэ? **/2 оноо/**

- A. Баримталж буй үзэл суртлын агуулгаар нь
B. Эрх мэдлийг хэрэгжүүлж буй байдлаар нь
C. Улс төрийн байр сууриар нь D. Үүргийн шинж чанараар нь
E. Зохион байгуулалт ба үйл ажиллагааных нь шинж чанараар

36. Иргэдийн улс төрийн оролцооны хэлбэрийг эрх зүйн байршлынх нь хүрээнд юу гэж ангилдаг вэ? **/1 оноо/**

- A. Хуулийн хүрээнд ба хууль бус B. Идэвхтэй ба идэвхгүй C. Нийцтэй ба нийцгүй
D. Сайн дурын ба албадлагын E. Уламжлалт ба уламжлалт бус

37. Эрх зүйт төрийн үндсэн шинжүүдийг зөв холбоно уу?

/2 оноо/

1	Хуулийн засаглал	a	Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, хуулиар олгосон эрх чөлөөгөө баталгаатай эдлэх бололцоог бүрдүүлж, хүний сайн сайхны төлөө төр тэмцдэг байх
2	Төр иргэн хоёр харилцан хариуцлага хүлээх	b	Нийгмийн харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн бусад хэм хэмжээг тухайн эрх зүйн харилцаанд оролцогч /субъект/ заавал дагаж биелүүлдэг байх
3	Төрөөс хүний эрхийг эрхэмлэн дээдэлж, баталгааг хангах	c	Иргэнээс эхлээд төрийн тэргүүн хүртэл, эсвэл засаг захиргааны нэгжээс эхлээд засгийн газар хүртэл хууль зөрчсөн л бол адилхан хариуцлага тооцдог байх

- A. 1b 2a 3c B. 1a 2c 3b C. 1b 2c 3a D. 1c 2b 3a E. 1c 2a 3b

38. “Ардчилал нь олон түмэн аз жаргалынхаа төлөө тэмцэж амь зуух эрх чөлөөгөө эдлэх найдвар мөн” гэж хэн хэлсэн бэ? **/2 оноо/**

- A. У. Черчилль B. Т.Жефферсон C. К. Поппер D. А.Линкольн E. Ж.Локк

39. Улс төр судлаач У.Рикер “Засаглалын идэвх төвийн ба муж нутгийн хооронд хуваарилагдаж тодорхой хүрээний асуудлаар эцсийн шийдвэр гаргадаг улс төрийн байгуулал” гэж босоо хуваарилалтын засаглалыг тодорхойлжээ. Энэ нь ямар засаглалыг хэлж байна вэ? **/2 оноо/**

- A. Хууль тогтоох засаглал B. Хэвтээ засаглал C. Гүйцэтгэх засаглал
D. Холбооны засаглал E. Шүүх засаглал

40. Улс төрийн намд хүлээлгэх хамгийн том шийтгэл юу вэ? **/1 оноо/**

- A. Сонгуульд орох эрхийг нь хязгаарлах
B. Мөнгөн торгууль буюу захиргааны арга хэмжээ авах
C. Хууль зөрчсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх
D. Улс төрийн хариуцлага хүлээлгэх E. Дээрх бүгд хамаарна

41. Үндсэн хуулинд Монгол улсын нийгмийн тулгуур харилцааг тодорхойлсныг дурьдахдаа илүүц зүйл нэрлэсэн бол олно уу? **/1 оноо/**

- A. Энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна.
B. Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна.
C. Төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна.
D. Монгол хэл бол төрийн албан ёсны хэл байна.
E. Нэг хэвшил бүхий эдийн засагтай байна.



42. Маргааныг шийдвэрлэх шүүхийн бус аргуудыг тоочихдоо хамааралгүй зүйл дурьдсан бол аль нь вэ? **/1 оноо/**
 А. Зуучлах В. Хэлэлцээ хийх С. Гэрээ байгуулах
 D. Эвлэрүүлэх E. Арбитрт хандах
43. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн гол зохицуулалт нь 1949 онд батлагдсан Женевийн конвенци болон тэдгээрийн нэмэлт протокол юм. Тэгвэл Женевийн эрх зүйн конвенциудад аль нь үл хамаарах вэ? **/2 оноо/**
 А. Тэнгисийн зэвсэгт хүчний шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийн нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн конвенци
 В. Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан, өвчтний нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн конвенци
 С. Дайны үед хүмүүсийг эрүүдэн шүүх, хууль бусаар саатуулах, энгийн иргэд болон иргэний байгууламжид халдахын эсрэг Женевийн конвенци
 D. Дайнд олзлогдогчидтой харилцах тухай Женевийн конвенци
 E. Дайны үед энгийн хүмүүсийг хамгаалах тухай Женевийн конвенци
44. Иргэний хувьд зөрчигдсөн эрхээ хамгаалах үндсэн арга аль нь вэ? **/1 оноо/**
 А. Аль нэг этгээд нь буулт хийх В. Иргэд хоорондоо тохиролцох
 С. Харилцан зөвшилцөх D. Нэхэмжлэл гаргах
 E. Аль нэг тал нь мөнгөн төлөөс төлөх
45. Нөхөж бичнэ үү.гэдэг нь хоёр ба түүнээс дээш талын хэлцэл буюу талууд өөрсдийн хүлээх эрх үүрэг, түүнийг өөрчлөх, биелүүлэх тухай харилцан тохиролцоог хэлнэ. **/2 оноо/**
 А. Хэлцэл В. Гэрээ С. Санал D. Гомдол E. Мэдэгдэл
46. Жижиг бизнес эрхэлж буй иргэдийн албан татварыг орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуулиар зохицуулдаг. Тэгвэл татвар ногдуулах аргачлалын дагуу патентаар татвар төлдөг ажил үйлчилгээ эрхлэгч аль нь вэ? **/1 оноо/**
 А. Биллиард тоглуулах үйлчилгээ эрхлэгч В. Хүнс барааны дэлгүүрийн эзэн
 С. Цайны газрын эзэн D. Лангуугаар худалдаа эрхлэгч иргэд
 E. Чингэлэг, тээврийн хэрэгсэл дээрээс худалдаа эрхлэгч
47. Хүмүүнлэгийн эрх зүйн зарчмуудыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг байгууллага аль нь вэ? **/2 оноо/**
 А. Олон улсын эрүүгийн шүүх В. Олон улсын шүүх
 С. Захиргааны хэргийн шүүх D. Давж заалдах шатны шүүх E. Улсын дээд шүүх
48. Прокурорын байгууллага ямар чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага вэ? **/1 оноо/**
 А. Шалгах В. Хяналт тавих С. Гэм бурууг тогтоох
 D. Өмгөөлөх E. Биелүүлэх
49. Иргэд улс орны хөгжлийн зорилго, нийгэм, эдийн засаг, төсвийн үндсэн үзүүлэлт, хууль, бодлогын баримт бичгүүд зэргийн талаар сайтар мэдэж, судалгаа, дүн шинжилгээ хийдэг байх нь төртэй харилцагч иргэнд тавигдах нийтлэг шаардлагын аль нь вэ? **/2 оноо/**
 А. Мэдээлэлтэй иргэн байх В. Оролцогч иргэн байх С. Хяналт тавигч иргэн байх
 D. Сонгогч иргэн байх E. Санхүүжүүлэгч иргэн байх
50. Захиргааны хариуцлагын тухай хуульд зөрчил гаргасан этгээдэд захиргааны шийтгэл оноохоор заасан байдаг. Захиргааны шийтгэл хүлээсэн иргэний эрхэд хамааралгүй зүйлийг олно уу. **/1 оноо/**
 А. Ямар зөрчил гаргаад шийтгэл хүлээж байгаагаа мэдэх
 В. Хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөх
 С. Зөрчил гаргасныг нотлох баримттай танилцах, зөрчлийн талаар тайлбар хийх
 D. Хуулийн туслалцаа авах, өмгөөлөгч авах
 E. Шийтгэлийг давж заалдах, шүүхэд гомдол гаргах



51. Субъект хоорондын харилцааны эрх үүргийг тухайн хэм хэмжээний хүрээнд харилцан тохиролцох үндсэн дээр тогтоож болдог олон улсын хэм хэмжээг юу гэж нэрлэдэг вэ?

/1 оноо/

A. Прогрессив В. Императив С. Экстенсив D. Диспозитив E. Интенсив

52. Олон улсын харилцаанд төр улсын сонирхлыг хуулийн хүчээр эсвэл хүч хэрэглэх гэсэн тэмцлийн хоёр төрлөөр хэрэгжүүлж болно гэж үзсэн эрдэмтнийг нэрлэнэ үү?

/1 оноо/

A. М.Вебер В. Д.Сингер С. Р.Арон
D. Ш.Монтескье E. Н. Макиавелли

53. Дараах өгөгдлүүдийн аль нь олон улсын харилцааны нэг туйлт системийн гол онцлог шинжийг илэрхийлж байна вэ?

/1 оноо/

- A. Өөрийн нөлөөнд буй улс орнуудын хоорондын зөрчилдөөнийг зохицуулах, эвсэлд нэгдсэн орнуудын салан тусгаарлах болон бие даах оролдлогыг таслан зогсоодог
B. Өөрсдийн хүчийг нэмэгдүүлэхийг байнга эрмэлздэг, нөгөө эвслийн гишүүнийг өөртөө татах, өөрийн гишүүдийг алдахгүйн төлөө тэмцдэг
C. Ноёрхогч шинжтэй болж буй аливаа улс, эвслийг эсэргүүцдэг
D. Нөгөө хоёр талтай аль алинтай нь сайн харилцаатай байх, зөрчил үүсэхээс болгоомжилдог
E. Аль нэг талтай нь дайтсан ч системийг тогтворгүйжүүлэх хэрэггүй гэж үздэг

54. Бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудыг зөв харгалзуулна уу?

/2 оноо/

1	Зүүн өмнөд Азийн орнуудын холбоо /АСЕАН/	a	Ази – Европын орнуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх байгууллага
2	Ази, Номхон далайн Эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга /АПЕК/	b	Зүүн өмнөд Азийн Эдийн засаг, нийгэм, соёлын салбарт хамтын ажиллагааг зохион байгуулах, энх тайван тогтвортой байдлыг буй болгоход дөхөм үзүүлэх зорилготой байгууллага
3	Ази – Европын уулзалт /АСЕМ/	c	Ази, Номхон далайн бүсэд олон талын чөлөөт худалдааны хөрөнгө оруулалттай нээлттэй зах зээл бий болгоход дөхөм үзүүлэх зорилготой байгууллага

A. 1c 2b 3a В. 1a 2c 3b C. 1b 2a 3c D. 1b 2c 3a E. 1c 2a 3b

55. Монгол улс гадаад бодлогын үзэл баримтлалаа 1992 оны шинэ Үндсэн хуулийн үзэл санааны дагуу боловсруулан Улсын Их Хурлаар баталсан байдаг. Энэхүү гадаад бодлогын үзэл баримтлалд аль нь үл нийцэх вэ?

/1 оноо/

- A. Олон тулгуурт байх В. Энхийг эрхэмлэсэн байх
C. Нээлттэй байх D. Бие даасан байх
E. Нөлөө бүхий улсуудтай харилцах

56. Монгол улс ямар бүс нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулах эрмэлзлэлтэй байдаг вэ?

/1 оноо/

- A. Европ В. Зүүн өмнөд Ази С. Зүүн хойд Ази
D. Төв ба Евразийн бүс нутаг E. Ойрхи дорнод ба Африк



ХОЁРДУГААР ХЭСЭГ**Санамж:**

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноо

2.1 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу? /6 оноо/

a	Нийгэмшил	1	Тодорхой нийтлэг сонирхол, үнэлэмжтэй хүмүүсийн нэгдэл
b	Нийгмийн бүлэг	2	Нийгмийн олон хэлбэрийн харилцааг зохицуулж, хийж гүйцэтгэх үйлдлүүдийг заасан байдал
c	Нийгмийн байр суурь	3	Нийгмийн чухал хэрэгцээг хангах, нийгмийн хэм хэмжээг зохицуулах чиг үүрэгтэй, тохируулагч байгууламж буюу нийгмийн дэд тогтолцоо
d	Нийгмийн институт	4	Гаж зан төлвийг арилгах орчин тойрныхоо чармайлт, гажуудагчийг шийтгэх, эсвэл засан хүмүүжүүлэх үйл явц
e	Нийгмийн хэм хэмжээ	5	Нийгмийн тогтолцоон дахь аливаа байр суурь, түүнд хамаарах эрх, үүрэг, бусдын зүгээс хандах хандлага
f	Нийгмийн хяналт	6	Нийгмийн соёл, туршлага, хэм хэмжээ, тогтсон чиг хандлага, үнэт зүйлсийг өөриймшүүлэх үйл явц

2.2 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу? /6 оноо/

a	ДНБ-ийг зардлаар тооцох арга	1	Тухайн жилд нийт үйлдвэрлэлээс олсон орлогын нийлбэр
b	ДНБ-ийг орлогоор тооцох арга	2	Үйлдвэрлэлийн хэрэгсэл шинээр худалдан авсан зардал
c	Мөнгө ашигласны төлбөр	3	Зээлийн хүү
d	ААН-ийн хөрөнгө оруулалтын зардал	4	Хэд хэдэн жилээр хуримтлагдсан төсвийн хомсдол
e	Цэвэр экспорт	5	Бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортоос импортыг хассан дүн
f	Улсын өр	6	Эцсийн хэрэглээний бүх зардлын нийлбэр

2.3 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу? /6 оноо/

a	Гэм буруу	1	Гэм буруутай төлбөр төлөгч тал
b	Гэм буруутан	2	Гэм буруутай этгээдийн хууль бус үйлдлийн улмаас учирсан хохирол
c	Гэм хор	3	Гэмт этгээд өөрийн үйлдлийн бурууг ойлгон ухаарах байдал
d	Хариуцагч	4	Хууль бус үйлдэл хийсэн, бусдад хохирол учруулагч этгээд
e	Хариуцлага	5	Гэмт үйлдлийн үр дүнд бий болсон алдагдал, гэмтэл, төлбөр
f	Хохирол	6	Гэм буруутай этгээд буруутай үйлдлийнхээ төлөө бусдын өмнө хүлээх үүрэг

2.4 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу? /6 оноо/

a	Эрх зүйт төр	1	Төр ард иргэдийг зохион байгуулахдаа тогтоодог, өөрийн гэсэн арга барил, дүрэм, журам
b	Социал төр	2	Төрийн зохион байгуулалт, удирдлага, түүнийг хэрэгжүүлэх арга
c	Төрийн хэлбэр	3	Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахын төлөө хуулийг дээдэлдэг төр ёсны мөн чанар буюу төр, иргэний нийгэм хоёр хууль эрх зүйн үндсэн дээр харьцангуй тэнцвэртэй орших арга загвар
d	Төрийн байгууламж	4	Тухайн орны нутаг дэвсгэр, засаг захиргааны бүтэц, нэгжийн хууль зүйн статус, төрийн төв болон орон нутгийн байгууллагын хоорондын харилцааны журам
e	Төрийн дэглэм	5	Албадлагын өвөрмөц аппаратад тулгуурлаж, бүх ард нийтэд хүрч байх улс төрийн засаглалын төвлөрсөн хэлбэр
f	Төрийн засаглал	6	Хүмүүсийн амьдралын наад захын нөхцөл бололцоо, нийгмийн хамгааллаар хангахад илүү чиглэсэн нийгмийн бодлого явуулах зорилго бүхий төрийн хэв маяг

